



**2017 оны 11 сар**

## АГУУЛГА

|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p><b>Тайланг бэлтгэсэн:</b></p> <p>Үндэсний Аудитын газрын харъяа Ховд аймгийн аудитын газар</p> <p>Аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор</p> <p>Л.Галбадрах</p> <p><b>Аудитын баг:</b></p> <p><b>Аудитор</b></p> <p>Б.Дамчуубалжир</p> <p><b>2017 оны 11 дүгээр сар</b></p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70433061 дугаарын факсаар харилцана уу.</p> <p><b>ХАЯГ:</b></p> <p>Аймгийн ЗДТГазрын байр, 3 дугаар давхар 302, 305, 313 тоот өрөө</p> | <p>Товчилсон үгийн тайлбар</p> <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй</p> <p><b>Бүлэг 1. Шилэн дансны сайтад 186 байгууллага мэдээлэлээ байршуулжээ.</b></p> <p><i>Шилэн дансны нэгдсэн сайтад 187 байгууллага мэдээлэлээ байршуулахаас 99.5 хувь буюу 186 байгууллага цэс нээлгэж 0.5 хувь буюу 1 байгууллага цэс нээлгээгүй байна. Мөн улс, орон нутгийн хөрөнгөөр санхүүжигдэж ажил үйлчилгээ гүйцэтгэдэг аж ахуйн нэгжүүд болон төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч болох хувийн цэцэрлэг, хувийн эмнэлэг, эмийн сангууд сайтад цэс нээлгээгүй байна.....6</i></p> <p>Шилэн дансны тухай хуулийг зохих түвшинд хэрэгжүүлжээ.....6</p> <p><b>Бүлэг 2. Хуульд заасан байгууллагууд мэдээллийг бүрэн мэдээлж хэвшээгүй байна.</b></p> <p>Аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуульд заасан 186 байгууллага мэдээлэл оруулсан ч сарын төсвийн гүйцэтгэлийг зохих түвшинд мэдээлж ирсэн байна.....7</p> <p>Байгууллагууд дараа жилийн төсвийн төсөл, хагас жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, аудитын дүгнэлт тайланд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ зэрэг мэдээллийг зохих түвшинд мэдээлээгүй байна.....7</p> <p><b>Бүлэг 3. Шилэн дансны мэдээллийг мэдээлэх албан тушаалтанууд үүргээ хангалтгүй биелүүлж байна.</b></p> <p>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд тавих дотоодын хяналтын байгууллагууд хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа ч үр нөлөө, ахиц дэвшил гараагүй байна.....10</p> <p>Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж мэдээлэх эрх бүхий зарим албан тушаалтанууд үүргээ хангалтгүй биелүүлсэн байна.....10</p> <p><b>Дүгнэлт.....13</b></p> <p><b>Зөвлөмж: .....14</b></p> <p>Албан шаардлага.....</p> <p>Тэргүүлэх аудиторын тушаал.....</p> <p>Хавсралт судалгаа.....</p> |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

## Товчилсон үгийн тайлбар

|                  |                                                     |
|------------------|-----------------------------------------------------|
| <b>УИХ</b>       | Улсын Их Хурал                                      |
| <b>ИТХ</b>       | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал                        |
| <b>ЗДТГ</b>      | Засаг даргын тамгын газар                           |
| <b>СТСХ</b>      | Санхүү төрийн сангийн хэлтэс                        |
| <b>ААГ</b>       | Аймгийн Аудитын газар                               |
| <b>НА</b>        | Нийцлийн аудит                                      |
| <b>ОНӨОААТҮГ</b> | Орон нутгийн өмчит аж ахуй тооцоот үйлдвэрийн газар |
| <b>ТӨҮГ</b>      | Төрийн өмчит үйлдвэрийн газар                       |
| <b>ААН</b>       | Аж ахуйн нэгж                                       |
| <b>ОНХС</b>      | Орон нутгийн хөгжлийн сан                           |
| <b>СХС</b>       | Сум хөгжүүлэх сан                                   |
| <b>ТӨХК</b>      | Төрийн өмчит хувьцаат компани                       |

## Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

**ᠠᠳᠤᠢᠳᠤᠨ ᠵᠣᠷᠢᠯᠲᠤ, ᠬᠠᠮᠠᠷᠰᠠᠨ ᠬᠦ᠋ᠷᠡᠭᠡ, ᠠᠷᠭᠠ ᠵᠦᠢ:** Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт аймгийн аудитын газраас 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг ᠵᠢ ᠠᠶᠢᠨᠡᠭᠦᠢ ᠣᠷᠢᠳᠡᠢ ᠠᠳᠤᠢᠳᠤᠨ ᠔᠔᠔ᠠᠭ ᠔᠔᠐ᠪᠡ᠋ᠠᠳ ᠔ᠢ ᠠᠢ ᠔᠔ᠢ ᠡᠡᠨᠢ ᠢ аймаг дахь Төрийн ᠠᠳᠤᠢᠳᠤᠨ ᠠᠵᠤᠳᠤᠢ ᠠᠵᠤᠳᠤᠢ ᠣᠳᠡᠡᠢ ᠣᠵᠤᠳᠤᠢ ᠠ ᠔ᠡᠡᠡᠭᠦᠭ.

**ᠠᠳᠤᠢᠳᠤᠨ ᠢ ᠴᠢ ᠔ᠡᠡ᠔, ᠔ᠠᠢ ᠳᠠᠬ ᠣᠵᠤᠳᠤᠭ:** Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв. Дээрх зорилтыг хангахын тулд дараахь дэд зорилтын дагуу аудит хийлээ.

- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд мэдээлэл хүргэх хэлбэрийг баримтлан, бүрэн хамрагдсан эсэх
- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлж байгаа эсэх
- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлсэн эсэх
- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх

**Хамарсан хүрээ, хугацаа:** Энэхүү аудитад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 2016 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2017 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртлэх хугацаанд Ховд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн хуулийн этгээдүүдийг 2015, 2016 онуудад аудитын дүн, мэдээлэлд үндэслэн аудитыг гүйцэтгэлээ. ҮАГ-аас ирүүлсэн төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу Шилэн дансны мэдээллийн хэрэгжилтийг өмнөх аудитаар бүрэн мэдээлэлсэн 26 байгууллагуудад итгэл үзүүлэн хэрэгжилт хангалтгүй байгууллагуудыг түүвэрлэн Монгол УИХурал, Засгийн газар, холбогдох яам, аймгийн ИТХурал, Засаг дарга, бусад байгууллагуудаас гаргасан холбогдох шийдвэрүүд, зохион байгуулсан ажлын үр дүн, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах арга хэмжээнүүдтэй холбоотой авсан арга хэмжээ, шилэн дансны нэгдсэн вэб сайт, байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагааг хамрууллаа.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн нийцлийн аудитад төрийн болон орон нутгийн өмчийн бүх байгууллага, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага болон хууль тогтоомжийн дагуу гэрээний үндсэн дээр төрийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа бүх байгууллагуудын шилэн дансы мэдээллийг хамруулж 2017 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс 11 дүгээр сарын 20-ныг хүртэл хугацаанд нийцлийн аудит хийлээ.

**Аудитын арга зүй:** Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, нийцлийн аудитын арга зүйг ашиглан, аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс, сум, байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудтай ярилцах, санал, асуулга, лавлагаа авах, дүн шинжилгээ хийх, тулган шалгах, газар дээр нь явж биет ажиглалт хийх зэрэг арга зүйг ашигласны зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын багийн бүрэлдэхүүн: Аудитыг Тэргүүлэх аудитор Л.Галбадрах удирдаж, Аудитын менежер А.Цэцэгсүрэн хянаж, аудитор Б.Дамчуубалжир хариуцан байгууллагуудын шилэн дансны хуулийн хэрэгжилтийн байдалд аудит хийж, дүнг нэгтгэн, ажлын тайланг бэлтгэв.

## ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Шилэн дансны тухай хуулийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар УИХурлаас 2014 оны 7 дугаар сард баталж, 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн байна.

Энэхүү хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын 2014 оны 384 тоот тогтоолоор “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ыг баталж, журмыг хэрэгжүүлж ажиллахыг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газар, хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага болон хууль тогтоомжийн дагуу гэрээний үндсэн дээр төрийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа гүйцэтгэгч нарт үүрэг болгожээ.

Ховд аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн 3.1.1-д заасан Төрийн өмчит болон орон нутгийн өмчит хуулийн этгээд 180, 3.1.2-т заасан төрийн өмчит үйлдвэрийн газрууд 3, 3.1.3-д заасан байгууллага 3, бүгд 186 байгууллага хамрагдаж байна.

## Бүлэг 1

*Шилэн дансны сайтад төрийн байгууллагууд мэдээллээ байршуулж хэвшсэн боловч хувийн аж ахуйн нэгжүүдийн цэс нээгдээгүйгээс мэдээлээгүй байна.*

*Шилэн дансны нэгдсэн сайтад 187 байгууллага мэдээллээ байршуулахаас 99.5 хувь буюу 186 байгууллага цэс нээлгэж 0.5 хувь буюу 1 байгууллага цэс нээлгээгүй байна. Мөн улс, орон нутгийн хөрөнгөөр санхүүжигдэж ажил үйлчилгээ гүйцэтгэдэг аж ахуйн нэгжүүд болон төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч болох хувийн цэцэрлэг, хувийн эмнэлэг, эмийн сангууд сайтад цэс нээлгээгүй байна.*

- 1.1 Ховд аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн 3.1.1-д заасан Төрийн өмчит болон орон нутгийн өмчит хуулийн этгээд 180, 3.1.2-т заасан төрийн өмчит үйлдвэрийн газрууд 3, 3.1.3-д заасан хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани 3, бүгд 186 байгууллага хамрагдаж байна.
- 1.2 Шилэн дансны нэгдсэн сайтад 186 байгууллагын цэс байгаа бөгөөд дээрх 1.1-д дурьдсан байгууллагуудаас гадна Эе эвийн хүч ОНӨҮГазар нь үйл ажиллагаа явуулж эхлээгүй тул Шилэн дансны нэгдсэн сайтад бүртгэгдээгүй, мэдээллээ оруулаагүй байна.
- 1.3 Хуулийн 3.1.4-д заасан хөрөнгө оруулалтын ажлуудыг аймаг сумдын ОНХС, бусад байгууллагуудад гэрээ байгуулан улс, орон нутгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг авч байгаа аж ахуйн нэгжүүд байгаа боловч тус байгууллагууд, мөн хуулийн 3.1.5 заасан төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч болох хувийн цэцэрлэг, хувийн эмнэлэг, эмийн сангууд байгаа боловч эдгээр байгууллагууд нь шилэн данс хөтөлдөггүй, шилэн дансны өөрийн гэсэн цэсгүй байгаа цэс нээж мэдээллийг байршуулах талаар өмнөх аудитаар холбогдох байгууллагад нь зөвлөмжийг хүргүүлсэн ч хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- 1.4 Цаашид Шилэн дансны тухай хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагуудтай бараа, ажил үйлчилгээг гүйцэтгэх тухай гэрээг байгуулахдаа хуулийн 6.9-д заасан мэдээллийг хуулийн хугацаанд нь тогтмол байршуулж байх шаардлагатай байна.

## Бүлэг 2

**Байгууллагууд төсвийн гүйцэтгэлээс бусад мэдээллийг бүрэн мэдээлж хэвшээгүй байна.**

**Улс, орон нутгийн төсвийн байгууллагууд сарын төсвийн гүйцэтгэл зохих түвшинд мэдээлж хэвшсэн ч тухайн жилийн батлагдсан төсөв, төсвийн хэмнэлт, хэтрэлтийн шалтгааны тайлбарыг бүрэн мэдээлээгүй байна.**

2.1 Нийт судалгаанд хамрагдсан 160 байгууллагаас 87 байгууллага нь тухайн жилийн батлагдсан төсвийг бүрэн тавьсан бөгөөд аймгийн хэмжээгээр 54,3 хувьтай байна. Харин 74 байгууллага батлагдсан төсвөө бүрэн байршуулаагүй байна.

2.2 ОНХС-гийн хөрөнгө батлагдаж захиран зарцуулж буй 18 байгууллага байгаагаас 8 байгууллага буюу 44,4 хувь нь мэдээллээ байршуулж 55,6 хувь буюу 10 байгууллагууд мэдээллээ байршуулаагүй байна.

2.3 Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээллийг оруулж хэвшсэн бөгөөд 2016 оны 10-р сараас 2017 оны 09-р сарын байдлаар оруулсан мэдээллийн хувийн дундаж 90,8 хувьтай мэдээллээ байршуулжээ. Нийт байгууллагын төсвийн гүйцэтгэлийн мэдээлэл байршуулсаныг графикаар үзүүлбэл:




**Байгууллагууд дараа жилийн төсвийн төсөл, хагас жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, аудитын дүгнэлт тайланд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ зэрэг мэдээллийг зохих түвшинд мэдээлээгүй байна.**

2.4 Дараа жилийн төсвийн төсөл, аудитын тайлан дүгнэлтэнд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээлэлийг 27,9 хувьтай мэдээлсэн байна.

- 2.5 Шилэн дансны мэдээлэлийг олон нийтэд мэдээлэх эрх бүхий байгууллагын нягтлан бодогч нар төсвийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгааны тайлбарыг бүрэн мэдээлж хэвшээгүйгээс аудитаар хэрэгжилт 11,5 хувьтай мэдээлсэн байна.
- 2.6 Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д заасан байгууллага болох 3 байгууллага нь 2017 оны 10-р сарын байдлаар 6.8-д заасан тогтмол мэдээлэх мэдээлэлтэй холбоотой мэдээллүүдийг зохих түвшинд мэдээлсэн байна.
- 2.7 Аудитын хавсралт судалгааны маягт №2-оос үзэхэд улсын төсвийн 26 байгууллагын 24 байгууллага нь төсөвт өөрчлөлт ороогүй, 2 байгууллага нь төсөвт өөрчлөлт орсон талаар мэдээлээгүй байна. Мөн улсын төсвийн 26 байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд өөрчлөлт ороогүй гэж мэдээлсэн байна.
- 2.8 Улсын төсвийн байгууллагуудаас тендер, худалдан авалттай холбоотой 2 байгууллагад гүйлгээ гарч мэдээллийн санд байршуулсан байна. Харин бусад улсын төсвийн 24 байгууллага нь энэхүү мэдээлэлтэй холбоотой үйл ажиллагаа гараагүй гэдгээ мэдээлсэн байна. Гэтэл байгууллагууд нь шатахуун, цэвэр бохир ус, дулаан халаалт зэргийн гэрээний өссөн дүнгээр тусгалгүй орхигдуулж, сар бүрийн гүйлгээгээр таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээний мэдээлэлд тусгадаг явдал байсаар байна
- 2.9 Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл 2 байгууллагад гарч мэдээллээ байршуулсан бол 24 байгууллага тухайн мэдээлэлтэй холбоотой үйл ажиллагаа гараагүй гэдгээ мэдээлсэн байна.
- 2.10 Улсын төсвийн байгууллагын хувьд цалингийн зардлаас бусад 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ 7144,9 сая төгрөгийн 309 гүйлгээ Санхүү төрийн сангийн дансны хуулгаар гарсанаас 5704,7 сая төгрөгийн 265 гүйлгээг мэдээлж 1440,2 сая төгрөгийн 44 гүйлгээг мэдээлээгүй байна. Шилэн дансны цахим сайтын мэдээлэлийг Сангийн яамны цахим сантай холбосноор 5,0 сая төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээ автоматаар байршиж байгаа боловч цалингийн зардалтай холбоотой гүйлгээ мэдээлэгдэх дутагдал байна. Харин орлогын мөнгөн гүйлгээнд 17030,1 сая төгрөгийн 450 гүйлгээ Санхүү төрийн сангийн хуулгаар гарч 8589,6 сая төгрөгийн 264 гүйлгээг мэдээлж 8440,5 сая төгрөгийн 186 гүйлгээг мэдээлээгүйгээс үзэхэд ихэнх байгууллагууд сар бүрийн санхүүжилтийн дүнг мэдээлж хэвшээгүй байна.
- 2.11 Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгслийн талаарх шийдвэр, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ

хамааралгүй байсан ба концессийн талаарх шийдвэрийн үйл ажиллагаа гараагүй, өр үүссэн шийдвэрийн талаар ихэнх байгууллагууд эдгээр ажил гүйлгээ гараагүй гэдгээ мэдээлсэн байна.

2.12 Шилэн дансны нэгдсэн цахим сайтад байгууллагуудын байршуулсан мэдээллийн хувийг графикаар харуулбал:



2.13 Сумуудад байгаа сум хөгжүүлэх сангийн мэдээлэл оруулах цэс байхгүйгээс сум хөгжүүлэх сангийн зээл олгох шийдвэр, олгосон зээл мэдээлэгдээгүй байна. Тухайлбал: Шилэн дансны хуулийн 6.4<sup>1</sup> дахь заалтыг зөрчин Булган, Жаргалант, Цэцэг сумууд 95.8 сая төгрөгний 8 орлогын гүйлгээ, Алтай, Булган, Зэрэг, Мөнххайрхан, Жаргалант, Үенч, Цэцэг сумууд 255.3 сая төгрөгний 25 зарлагын гүйлгээг тухай бүрт нь мэдээллээгүй, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого зарлагын гүйлгээг байршуулж мэдээллээгүй дутагдал бүх сумдад байна.

2.14 Аймгийн CTCX-ээс байгууллагуудын гүйлгээний хуулга авч цалингийн зардлаас бусад 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын гүйлгээг мэдээлсэн эсэхийг хянахад 2016 оны 10 сарын 01-нээс 2017 оны 10 сарын 01-ний байдлаар сумдын дүнгээр нийт 5274,6 сая төгрөгийн дүнтэй 253 зарлагын гүйлгээ гарсанаас 3471,0 сая төгрөгийн 159 гүйлгээг мэдээлж 1803,6 сая төгрөгийн 94 гүйлгээг мэдээлээгүй, 42360,1 сая төгрөгийн дүнтэй 1176 орлогын гүйлгээ гарсанаас 13374,5 сая төгрөгийн 293 гүйлгээг мэдээлж 28985,6 сая төгрөгийн 883 гүйлгээг мэдээлээгүй байна.

<sup>1</sup> цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрээр тухай бүр цахим сайтад тогтмол мэдээлнэ

## Бүлэг 3

*Шилэн дансны мэдээллийг мэдээлэх эрх бүхий зарим албан тушаалтанууд үүргээ хангалтгүй биелүүлж байна.*

*Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд тавих дотоодын хяналтын байгууллагууд хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа ч үр нөлөө, ахиц дэвшил гараагүй байна.*

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх тогтоол шийдвэр аймгийн ИТХурлаас 2017 оны 10 дугаар сарын байдлаар ямар нэгэн тогтоол шийдвэр гараагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 8.2-т заасны дагуу аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд Аймгийн Засаг даргын 2015 оны “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих тухай” А/06 тоот захирамж, “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай” А/07 тоот захирамж гарч ажлын хэсэг байгуулжээ.

Хуулийн 5.3-т заасны дагуу Санхүүгийн хяналт аудитын алба шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг 2016 оны 9 сараас эхлэн хяналтын эрхтэйгээр ашиглаж эхэлсэнтэй холбоотой Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны нэгдсэн системд мэдээлэл бүрэн орж байгаа эсэх талаар сар, улирал бүр мэдээлж байхыг даалгасны дагуу төсөвт шууд захирагч нарын хуулийн хэрэгжилтийг зохих түвшинд ханган ажилласан ч үр нөлөө, ахиц дэвшил гараагүй байна.

2017 онд Ховд аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа байгууллагуудын төсвийн шууд захирагчдад хариуцлага тооцохоор сонсох ажиллагаа явуулах тухай албан тоотыг хүргүүлж ажилласан байна.

Аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн аудитын дүнгээс дүгнэж үзэхэд Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоодын хяналт шалгалтыг тогтмол хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлж, шалгалтын дүнгээр тодорхой арга хэмжээ авч ажилласан, шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг ашиглаж байгаатай холбоотойгоор хяналт шалгалтын үр нөлөө дээшилсэн мэт харагдаж байгаа ч гарсан ажил гүйлгээг бодит тоон дүнгээр нь мэдээлэлгүй “байхгүй” гэж мэдээлэх явдал гарч байна.

Тухайлбал таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын гүйлгээг байршуулалгүй холбогдох гүйлгээ, тухайн жилийн батлагдсан төсөв, дараа жилийн төсвийн төсөл, санхүүгийн хагас жилийн тайлан зэрэг мэдээллүүдийг мэдээлэлгүй орхигдуулж, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн зэрэг мэдээллүүдийг тоон мэдээлэл ашиглалгүй “**гүйлгээ гараагүй, байхгүй, үгүй**” гэх мэт үгэн хэлбэрээр мэдээлэж байгаа нь Шилэн дансны цахим хуудасны хяналтын эрхээр хяналт хийж тоо мэдээг нэгтгэхэд хүндрэл учруулах хандлагатай байна. Иймд энэ талаар тодорхой мэдээллийг тогтмол өгч сургалт хийх хэрэгцээ шаардлага урган гарч байна.

**Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг 50,0 хувьтай хэрэгжүүлэн ажилласан байна.**

| Д/д                                     | Зөвлөмж<br>өгөгдсөн албан<br>тушаалтан    | Зөвлөмжийн утга                                                                                                                                                                                                                                                              | Зөвлөмжийн хэрэгжилтийг<br>хангасан байдал                                                                                                                                                                                                                                       | Хэрэгж<br>илтийн<br>хувь |
|-----------------------------------------|-------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|
| 1                                       | Аймгийн засаг<br>дарга<br>Д.Галсандондогт | Шилэн дансны<br>нэгдсэн мэдээлийн<br>цахим хуудсанд<br>мэдээллээ бүрэн<br>оруулаагүй төсвийн шууд<br>захирагч нарт<br>хариуцлага тооцох.                                                                                                                                     | 2017 онд Ховд аймгийн<br>төсвийн ерөнхийлөн<br>захирагчаас Шилэн<br>дансны тухай хуулийн<br>хэрэгжилт хангалтгүй<br>байгаа байгууллагуудын<br>төсвийн шууд захирагчдад<br>хариуцлага тооцохоор<br>сонсох ажиллагаа явуулах<br>тухай албан тоотыг<br>хүргүүлж ажилласан<br>байна. | 100                      |
| 2                                       |                                           | Улс орон нутгийн<br>төсвийн хөрөнгөөр ажил<br>гүйцэтгэсэн аж ахуйн<br>нэгжүүдтэй гэрээ<br>байгуулахдаа Шилэн<br>дансны хуулийг ханган<br>ажиллах талаар заалт<br>оруулж, ААН-үүдээр<br>мэдээллийг хуулийн<br>хугацаанд нь тогтмол<br>байршуулах арга хэмжээг<br>хэрэгжүүлэх. | Хэрэгжүүлээгүй                                                                                                                                                                                                                                                                   | 0                        |
| Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь /дунджаар/ |                                           |                                                                                                                                                                                                                                                                              |                                                                                                                                                                                                                                                                                  | 50                       |

Аймгийн аудитын газраас 2016 оны 11-р сард хийгдсэн шалгалтаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж мэдээллээ хангалтгүй оруулсан байгууллагын удирдлагуудад хариуцлага тооцон биелэлтийг гаргуулж ажилласан байна.

### **Аудитаар илэрсэн зөрчил.**

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар шилэн дансны цахим санд мэдээлбэл зохих 40669,9 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй зөрчил илэрлээ. Үүнд:

1. Цалингийн зардлаас бусад 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээний хувьд улсын төсвийн 8 байгууллага 44 удаагийн 1440,2 сая төгрөгийн гүйлгээ, орон нутгийн төсвийн болон ТШЗ-ийн 27 байгууллага 94 удаагийн 1803,6 сая төгрөгийн гүйлгээ, нийт 3243,8 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй байна.
2. 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээний хувьд улсын төсвийн 18 байгууллага 186 удаагийн 8440,5 сая төгрөгийн гүйлгээ, орон нутгийн төсвийн болон ТШЗ-ийн 93 байгууллага 886 удаагийн 28985,6 сая төгрөгийн гүйлгээ, нийт 37426,1 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй байна.
3. Тухайн жилийн төсвийг 01-р сарын 10-ны өдрийн дотор мэдээлэхээс улсын төсвийн 12 байгууллага, орон нутгийн болон ТШЗ-ийн 54 байгууллага, 4 орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн 5 байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газрын 3 байгууллага нийт 74 хуулийн этгээд мэдээлээгүй байна.
4. ОНХС-гийн төлөвлөгөөг жил бүрийн 01-р сарын 10-ны өдрийн дотор мэдээлэхээс мэдээлвэл зохих 18 байгууллагаас 10 байгууллага мэдээлээгүй байна.
5. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг жил бүрийн 01-р сарын 10-ны өдрийн дотор мэдээлэхээс орон нутгийн болон ТШЗ-ийн 11 байгууллага мэдээлээгүй байна.
6. Дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор мэдээлэхээс улсын төсвийн 16 байгууллага, орон нутгийн болон ТШЗ-ийн 90 байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн 1 байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газрын 2 нийт 109 хуулийн этгээд мэдээлээгүй байна.

7. 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор мэдээлэхээс улсын төсвийн 14 байгууллага, орон нутгийн болон ТЗШ-ийн 60 байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн 3 байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газрын 3 нийт 80 хуулийн этгээд мэдээлээгүй байна.
8. Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор мэдээлэхээс улсын төсвийн 14 байгууллага, орон нутгийн болон ТЗШ-ийн 87 байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн 5 байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газрын 3 нийт 109 хуулийн этгээд мэдээлээгүй байна.
9. Төсвийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарыг улирал бүр мэдээлэхээс улсын төсвийн 22 байгууллага, орон нутгийн болон ТЗШ-ийн 111 байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн 4 байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газрын 2 нийт 139 хуулийн этгээд мэдээлээгүй байна.

**Шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитаар улсын төсөвт 3 байгууллага, орон нутгийн төсөвт 44 байгууллага, ОНӨҮГазрын 2 байгууллага, ТӨҮГазрын 1 байгууллага, нийт 50 байгууллагын төсвийн шууд захирагч нарт хариуцлага тооцуулах албан шаардлагыг төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлээ.**

## **ДҮГНЭЛТ**

*Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын үр дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна.*

1. *Шилэн дансны нэгдсэн сайтад 186 байгууллага мэдээллээ байршуулсан байгаа бөгөөд эдгээр байгууллагууд нь жилийн батлагдсан төсөв, сарын төсвийн гүйцэтгэл зэргийг зохих түвшинд мэдээлж хэвшсэн байна.*
2. *Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээний хувьд ихэнх байгууллагууд сар бүрийн санхүүжилтийг орлогын гүйлгээгээр мэдээлж хэвшээгүй байна.*

3. Улс, орон нутгийн хөрөнгөөр санхүүжигдэж ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа ААН-үүд, Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч болох хувийн цэцэрлэг, хувийн эмнэлэг, эмийн сангууд хуулиа хэрэгжүүлж ажиллах талаар өмнөх аудитаар зөвлөмж өгсөн ч зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд тавих дотоодын хяналт үр нөлөө дээшилсэн байна.

## Зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн Аймгийн засаг дарга Д.Галсандондог-т зөвлөх нь:

1. Шилэн дансны нэгдсэн мэдээлийн цахим хуудсанд мэдээллээ бүрэн оруулаагүй төсвийн шууд захирагч нарт хариуцлага тооцох.
2. Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй Улс, орон нутгийн хөрөнгөөр санхүүжигдэж ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа ААН-үүд, Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч болох хувийн цэцэрлэг, хувийн эмнэлэг, эмийн сангуудад төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг олгохгүй байх талаар гэрээндээ тодорхой тусгаж хариуцлагыг сайжруулж ажиллах.
3. Шилэн дансны тухай хууль, эрх зүйн актуудыг сурталчилах ажлыг эрчимжүүлж, төсвийн төвлөрүүлэн захирагч, шууд захирагч, байгууллагын нягтлан бодогч нарыг нэгдсэн арга зүйгээр хангаж, аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгуулж ажиллах.

ТАЙЛАНГ ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Л.ГАЛБАДРАХ

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Б.ДАМЧУУБАЛЖИР



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2017 оны 11 сарын 21 өдөр

Дугаар 37

Ховд

Аудитын тайлан, зөвлөмж,  
албан шаардлага батлах тухай

Төрийн Аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7, 15 дугаар зүйлийн 15.1.12 дугаар заалт Монгол Улсын Ерөнхий аудиторов 2016 оны А/95 тоот тушаалаар баталсан "акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1, 4.1 дэх заалт, аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторов дэргэдэх зөвлөлийн 2017 оны 11 сарын 21-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ нь:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитын тайлан, зөвлөмж, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

2. Нийцлийн аудитын дүгнэлтэнд үндэслэн аймгийн Засаг дарга Д.Галсандондогт ДААЛГАХ нь:

2.1 Шилэн дансны нэгдсэн мэдээлийн цахим хуудсанд мэдээллээ бүрэн оруулаагүй төсвийн шууд захирагч нарт хариуцлага тооцох.

2.2 Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй Улс, орон нутгийн хөрөнгөөр санхүүжигдэж ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуй нэгжүүд, Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч болох хувийн цэцэрлэг, хувийн эмнэлэг, эмийн сангуудад төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг олгохгүй байх талаар гэрээндээ тодорхой тусгаж хариуцлагыг сайжруулах.

2.3 Шилэн дансны тухай хууль, эрх зүйн актуудыг сурталчилах ажлыг эрчимжүүлж, төсвийн төвлөрүүлэн захирагч, шууд захирагч, байгууллагын нягтлан бодогч нарыг нэгдсэн арга зүйгээр хангаж, аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгуулах.

2.4 Албан шаардлагын дагуу авсан арга хэмжээний шийдвэрийг 12 дугаар сарын 15-ны дотор ирүүлэх.

3. Нийцлийн аудитын зөвлөмж, тавьсан албан шаардлагыг барагдуулж дүнг 12 дугаар сарын 20-ны дотор танилцуулахыг аудит хийсэн аудитор Б.Дамчуубалжирт хариуцуулсугай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.ГАЛБАДРАХ

0800028

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны  
11 сарын 21 өдрийн 37 дугаар тушаалын  
хавсралт

Шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт

| № | Төлбөр, зөрчил хариуцагчийн |                             | Төлбөр зөрчлийн товч утга                                                                                               | Аудиторын нэр   | Актны дугаар | Төлбөрийн дүн | Албан шаардлагын | Зөрчлийн дүн |
|---|-----------------------------|-----------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------|--------------|---------------|------------------|--------------|
|   | Нэр                         | Албан тушаал                |                                                                                                                         |                 |              |               |                  |              |
| 1 | Д. Галсандондог             | Аймгийн Засаг дарга         | Шилэн дансны цахим хуудсанд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулаагүй                             | Б. Дамчуубалжир |              |               | 1/68             | 3131.2       |
| 2 | Ц. Мягмарсүрэн              | Эрүүл мэндийн газрын дарга  | Булган сумын хүн эмнэлэг нь шилэн дансны цахим хуудсанд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулаагүй | Б. Дамчуубалжир |              |               | 2/69             | 112.6        |
| 3 | Б. Сайнбаяр                 | Ховд их сургуулийн захирагч | Шилэн дансны цахим хуудсанд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулаагүй                             | Б. Дамчуубалжир |              |               | 3/70             |              |
| 4 | Д. Энхсайхан                | Ховд дулааны станц ТӨХК     | Шилэн дансны цахим хуудсанд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулаагүй                             | Б. Дамчуубалжир |              |               | 4/71             |              |
|   |                             |                             | НИЙТ ДҮН                                                                                                                |                 |              | 0.00          |                  | 3243.8       |

Хавсралт үйлдсэн: Аудитор

Б. Дамчуубалжир